

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн
77 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Эдийн засаг, хөгжлийн яам

Албан тушаалын нэр:

Технологи, инновацын шилжилт, эрчимт
хөгжлийн судалгааны хэлтсийн дарга

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн
бодлогын газрын Технологи,
инновацын шилжилт, эрчимт хөгжлийн
судалгааны хэлтэс

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Эрхэлсэн түшмэл, ТЗ-3

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын
XI байр

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ


Албан тушаалын зорилго:

Технологи, инновацад суурилан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх, үндэсний инновацын экосистем, шинжлэх ухааны паркийг хөгжүүлэх чиглэлээр богино, урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, хууль тогтоомж болон бусад эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох, санал, шийдвэрийн төсөл боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, бодлогын шийдлийг тодорхойлж, хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах, нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил, арга зүйгээр хангах, үр дүнг газрын даргын өмнө хариуцна.


Албан тушаалын зорилт:

- 1.Технологи, инновацад суурилан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх чиглэлээр богино, дунд, урт хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, хууль тогтоомжийн төсөл болон бусад эрх зүйн баримт бичиг, санал, шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах;
- 2.Шинэ технологи, инновацыг судалгаа, хөгжүүлэлтийн шатнаас зах зээлд амжилттай нэвтрүүлэх, дамжуулах, гарааны компаниудын үйл ажиллагааг дэмжих бодлого, төлөвлөлт, эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журмыг боловсруулж, батлуулах, хэрэгжилт хангах;
3. Гадаад (Засгийн газар, яамд хоорондын санамж бичиг, хамтран ажиллах гэрээний хүрээнд болон олон улсын сан хоорондын хамтарсан)-тай хамтарсан болон дотоодын хамтарсан төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах, хамтарсан төслийн сонгон шалгаруулалт, хэрэгжилтийг бодлого, зохион байгуулалтаар ханган ажиллах, гүйцэтгэл, үр дүнд хяналт тавих, тайлагнах
4. Үндэсний инновацын экосистемийг хөгжүүлэх.
- 5.Шинжлэх ухааны парк байгуулах, кластерын тогтолцоог хөгжүүлэх бодлого, чиглэл, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангах, холбогдох байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 6.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Технологи, инновацад суурилан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх чиглэлээр богино, урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг удирдамжаар хангах;	Богино, урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулсан байна.	Г, Х
	2.Технологи, инновацад суурилан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлыг удирдамжаар хангах;	Холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгосон байна.	Г, Х
	3.Оюуны өмчийн хамгаалалтыг сайжруулах, шинэ технологи, инновацыг зах зээлд нэвтрүүлэхэд шаардлагатай хууль, журам, дүрэм стандартыг шинэчлэх ажлыг зохион байгуулах;	Оюуны өмчийн хамгаалалтыг сайжруулах, шинэ технологи, инновацыг зах зээлд нэвтрүүлэхэд шаардлагатай хууль, журам,	Г, Х




		дүрэм стандартыг шинэчилсэн байна.	
	4.Технологи, инновацын дэд бүтцүүдийг төлөвлөх, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Технологи, инновацын дэд бүтэц бий болсон байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хувийн хэвшлийн технологи хөгжүүлэлт, нутагшуулалт, инновацыг дэмжих, урамшуулах эрх зүйн орчныг бий болгож, хэрэгжилтийг зохион байгуулах;	Инновацыг дэмжих, урамшуулах эрх зүйн орчныг бий болгож, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.	Г, Х
	2.Технологи, инновац дамжуулах, нутагшуулах төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Технологи, инновац дамжуулах, нутагшуулах төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	3.Технологи, инновацыг хөгжүүлэх, турших, зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх тусгай сан байгуулах, төрийн болон хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн механизмыг бий болгох ажлыг зохион байгуулах;	Тусгай сан байгуулж, төрийн болон хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн механизмыг бий болгосон байна.	Г, Х
	4.Технологи, инновацад суурилсан бизнесийг дэмжих, гарааны компани байгуулах, хөгжүүлэх эрх зүйн орчин болон стратеги боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Эрхзүйн орчин бүрдэж, стратеги хэрэгжсэн байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын байгууллагатай хамтран ажиллах, удирдлага зохицуулалтаар хангах.	Хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г,Х,Т
	2.Эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны механизм бий болгох ажлыг зохион байгуулах;	Хамтын ажиллагааны механизм бий болсон байна.	Г, Х



	3.Хувийн хэвшилд судалгаа хөгжүүлэлтийн үр дүнг нэвтрүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;	Дотоодын үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлсэн байна.	Г, Х
	4.Гадаадын технологи дамжуулах төв, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллаж, шилдэг технологиудыг тэргүүлэх салбаруудад нутагшуулах ажлыг зохион байгуулах.	Тэргүүлэх салбаруудад технологи нутагшуулах ажлыг зохион байгуулсан байна.	Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Инновац, технологийн хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохицуулах.	Инновац, технологийн хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохицуулсан байна.	Г, Х
	2.Инновацын үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчин, зохицуулалтыг боловсронгуй болгох.	Инновацын үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчин, зохицуулалтыг боловсронгуй болгосон байна.	Г, Х
	3.Инновацын соёлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, залуу судлаачид, мэргэжилтнүүдийн оролцоог нэмэгдүүлэх.	Инновацын соёлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлж, залуу судлаачид, мэргэжилтнүүдийн оролцоог нэмэгдүүлсэн байна.	Г, Х
5 дугаар зорилтын хүрээнд	1.Шинжлэх ухааны парк, кластерын тогтолцоог байгуулж ажиллуулахтай холбогдсон эрх зүйн орчныг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах;	Эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	Г,Х
	2.Шинжлэх ухааны парк, кластерын тогтолцоог байгуулах чиглэлээр дотоод, гадаадын байгууллагатай хамтарч ажиллах, хөрөнгө оруулалтыг дэмжих, Шинжлэх ухааны паркийн бүтээн байгуулалтын	Шинжлэх ухааны паркийн бүтээн байгуулалтын ажлыг удирдлагаар хангасан байна.	Г,Х




	ажлыг удирдлагаар хангах;		
	3.Шинжлэх ухааны парк, кластерын тогтолцоог байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, боловсруулах, паркийн нэгжийн хэвийн үйл ажиллагаа явуулахад заавар, удирдамжаар хангах.	Паркийн тогтвортой, тасралтгүй үйл ажиллагааг бүрдүүлсэн байна.	Г,Х, Т
6 дугаар зорилтын хүрээнд	1.Удирдлагаас өгч буй үүрэг, цаг үеийн арга хэмжээнд оролцох, эргэн тайлагнахад удирдлага, чиглэлээр хангах;	Үүрэг даалгаврын дагуу ажил, үүргийг хийж гүйцэтгэсэн байна.	Г, Х
	2.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, баталгаажуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах, хянах;	Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, ажил үйлчилгээ үр дүнтэй хэрэгжиж, үнэн зөв тайлагнасан байна.	Г, Х
	3.Нэгжийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах;	Удирдлагаар ханган ажилласан байна.	Г, Х
	4.Нэгжийн хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбоотой мэдээ, тайлан, судалгаа гаргах, танилцуулах ажлыг хянах;	Мэдээ, тайлан, судалгаа үнэн зөв, хугацаандаа гарсан байна.	Г, Х
	5.Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг даган мөрдөж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд зохих журмын дагуу тухай бүр мэдүүлж байх;	Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг даган мөрдөж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан ажилласан байна.	Г
	6.Баримт бичгийн стандартад тодорхойлсон техникийн шаардлагуудыг мөрдлөг болгон ажиллаж, зохион бүрдүүлсэн баримтаараа Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн дараа оны эхний улиралд багтаан байгууллагын архивд хүлээлгэн өгөх;	Стандартад тодорхойлсон техникийн шаардлагуудыг мөрдлөг болгон ажилласан байна.	Г



	7.Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол, ур чадвараа тогтмол дээшлүүлэх;	Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол, ур чадвараа тогтмол дээшлүүлсэн ажилсана байна.	Г
	8.Яамны хөдөлмөрийн дотоод журам, яамны үйл ажиллагааны хүрээнд гарсан бусад дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах.	Дүрэм, журам, зааврыг мөрдөж ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	- Санхүү /0412/; - менежмент ба удирдахуй /0413/; - эрх зүй /0421/; - мэдээлэл, харилцаа холбооны технологи /0613/ - бизнес удирдлага, эрх зүйд хамаарах салбар дундын чиглэл /0488/ - нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүлзүй /0321/ - инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл /0713/ - байгалийн шинжлэх ухаан /0532/		
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх;		
Туршлага	- Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх; - хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 4-өөс доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; - санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх; - байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх.	
	Дүн шинжилгээ хийх	- мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, системийн шинжилгээ хийх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, харьцуулсан судалгаа хийх; - бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах.	
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - хуульд нийцсэн шийдвэр гаргах; - оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; - аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль, тогтоомж шийдвэрийн төсөлд тусгах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээг баримталж шийдвэр гаргах; - гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх.	
	Манлайлах	- ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дуурайл үзүүлэх;	



		- ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх.
	Бусад	- кирилл болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх; - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - гадаад хэл, мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай бусад ур чадвар.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- Шинжээч-1
- Ахлах мэргэжилтэн-1

Нийт-2

Бусад харилцах субъект

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн холбогдох албан тушаалтан;
- Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын холбогдох албан тушаалтан;
- Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Албан тушаал:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:

Дугаар:

2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр